

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Чойжмаагийн Лам –Авар	Дугаар	L057
Оршин суугаа аймаг	Дорнод	Оршин суугаа сум	Хэрлэн сум
Төрсөн газар	Дорнод аймаг Хэрлэн сум (Чойбалсан хот)	Төрсөн он	1926
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Ялгуулсны Доод болон Дээд хийд	Сүм хийдийн дугаар	ДОЧБ 011, ДОЧБ 012
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 10	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Дорнод аймгийн Чойбалсан сумын Ялгуулсаны Доод болон Дээд хийд

-Та нутаг орондоо байсан сүм хийдийн талаар ярьж өгнө үү?

Би тэгэхэд жаахан хүүхэд байсан. Нэг жижигхэн хийд байсан.Түүний баруунтаа том цамтай, майдартай хийд байсан.Наана Гэгээний хийд гэж байсан. Аймаг дээр хойд урд хоёр хүрээ байсан. Тэрний урд бас нэг хийд байсан санагдаж байна. Би Чойбалсан сумын хүн. Манай сумд 4 хийд байсан юм шиг байгаа юм. Хөгшний хүрээний бунхан, зүүнтшээ Талбай гээд бас нэг юм байсан юм шиг байгаа юм.

-Та сүүлчийн Ялгуулсан хутагтын хамаатан хүн гэнэ?

Манай ээж 3 ахтай хүн. Хамгийн том ах нь Жадамба гэж тайж хүн байгаад баригдаж алуулсан. Дүүний дараагийнх нь Тойвсамбуу гэж Баруун хийдэд маарамба байсан хүн. Бас 30 хэдэн онд баригдаж алуулсан. Нэг хар хүн байсан. Тэр нь өөрийн үхлээр үхсэн. Тэгээд манай ээжийн том ахын хүүхэд л юм болов уу гэж санадаг.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Нэр нь хэн гэдэг байсан юм бол? 8 дүр тодорсон гэдэг үү?

Тийм. 8 дахь дүр нь байсан юм гэдэг. Гомбодоржийн Лувсанданзанням гэдэг нэртэй. 22 настайдаа 37, 38 онд баригдсан гэдэг яриа байдаг. Төрсөн газар нь овоо нь байдаг. Бид очиж ёслол үйлддэг.

-Төрсөн газар нь хаана байдаг юм бэ?

Хутаг уулын зүүнхэнтээ голын үрд дэнж дээр төрсөн. Одоо тэнд овоо нь бий.

Хэн гэдэг айлд төрсөн?

Жадамбынх гэдэг айлд төрсөн юм гэсэн. Жадамба тайжын зарц хүүхнээс төрсөн. Төрөхдөө хөөгдөж гадаа төрсөн гэдэг. Тэр бол зарц нь ч биш жинхэнэ авгайнх нь хүүхэд гэж байгаа юм. Ер нь манай аймаг намайг багад хүн төрөхдөө гэртээ төрдөггүй үгүй бол овоохой барьдаг. Ийм уламжлалтай байсан. Энэ уламжлалтай холбож боддог юм. Яагаад тэгдэгийг би мэдэхгүй.

-Ялгуулсан хутагтын хийд хэзээ байгуулагдсан?

Тэрийг мэдэхгүй.